



**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ
ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХ**

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын
дагуу бэлтгэгдсэн Санхүүгийн Тайлан болон
Хараат бус Аудиторын Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА

САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ	4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	7
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
1. Сангийн ерөнхий мэдээлэл	11
2. Сангийн үйл ажиллагаа явуулж буй орчин	12
3. Тайлан бэлтгэх үндэслэл	13
4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд	15
5. Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт	23
6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд	24
6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд (үргэлжлэл)	25
7. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба дансны үлдэгдлүүд	26
8. Хууль дүрэм журам нийцэл	28
9. Хүүгийн орлого	28
10. Ногдол ашгийн орлого	29
11. Бусад орлого	30
12. Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үүссэн олз, гарз	30
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз	30
14. Сангийн үйл ажиллагааны зардал	31
15. Бусад зардал	31
16. Орлогын албан татвар	32
17. Хөрөнгө оруулалт	32
18. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	34
19. Бусад авлага	35
20. Нэгж эрх	35
21. Бусад нөөц	35
22. Бусад өглөг	36
23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага	36
24. Капиталын удирдлага	48
25. Болзошгүй өр төлбөр ба үүрэг	48
26. Бодит үнэ цэнийн тодруулга	49
27. Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх тогилуулга	51
28. Тайлант хугацааны дараах үйл явдлууд	52
29. Англи хэл дээрх орчуулга	52

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК

САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр:	Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК ("Сан" гэх) 2021 оны 04 сарын 07-ны өдөр үүсгэн байгуулагдсан.	
Төлөөлөн Удирдах Зөвлөл:	Н.Монсор	ТУЗ-ийн дарга
	Ч.Анхбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Ц.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Ж.Дэлгэрсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Р.Сугархүү	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гүйцэтгэх захирал:	Г.Ганзориг	
Гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн төлөөлөгч	Н.Болор-Эрдэнэ	
Гүйцэтгэх удирдлагууд:	О.Мандухай	Ерөнхий нягтлан бодогч
Хөрөнгө оруулалтын менежментийн компани:	"Мандал Ассет Менежмент" ХХК	
Кастодиан банк:	Голомт Банк ХК-ийн кастодиан үйлчилгээний хэлтэс	
Харилцагч банк:	Голомт Банк ХК	
	Хаан Банк ХК	
	Капитрон Банк хаалттай ХК	
	Худалдаа Хөгжлийн Банк ХК	
	М Банк хаалттай ХК	
	Богд Банк ХК	
	Тээвэр Хөгжлийн Банк ХК	
	Ариг Банк ХК	
Бүртгэлтэй хаяг:	Хас Банк ХК	
	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	
Аудитор:	Мерү тауэр 6 давхар 602 тоот, Жамьяан Гүний гудамж, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс	
	Нексия Глобал Монголиа Аудит ХХК Эмбасси Уан Бюлдинг, 606 тоот, 6-р давхар, Элчингийн гудамж 15А, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14220, Монгол Улс	

Мандал Ирээдүйн Өсөлт
Хамтын ХОС ХХК

Улаанбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүний гудамж, Мөрү талар, 602 тоот
Шуудангийн хайрцаг – 2292,
Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7272 9911

2026 оны 02 сарын 11

Дугаар №26/029

Улаанбаатар хот

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Энэхүү тайланд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй уншигдах дараах мэдэгдэл нь Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид "Сан" гэх) 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.


Сан удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагнагч Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлага ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Сангийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг шалгахыг зөвшөөрч байна.



Н.Болор-Эрдэнэ

Гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн төлөөлөгч



О.Мандухай

Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 2 сарын 11

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

"Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК (цаашид "Сан" гэх)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Сангийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Сангийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтад удирдлага хариуцлага хүлээнэ.

Сангийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Сангийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Сангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Сангийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Сангийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Сангийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Сангийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Сангийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын сан ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн сангийн нэгж эрх эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид



Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 2 дугаар сарын 11-ний өдөр

Нексия Глобал Монголиа Аудит ХХК

Нексия Интернэйшнл-ийн албан ёсны гишүүн

Вэб: www.nexia.com

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2025	2024
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	9	7,681,785	3,843,793
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	9	1,464,757	3,962,322
Ногдол ашгийн орлого	10	2,507,687	1,509,205
Бусад орлого	11	-	86,777
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз/ гарз	12	(534,910)	1,104,430
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалд шилжүүлсэн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	12	(299,793)	51,058
Нийт орлого		10,799,526	10,557,585
ХОМК-ийн үйлчилгээний зардал	14	(1,687,472)	(1,502,480)
Кастодианы үйлчилгээний зардал	14	(72,518)	(62,494)
Бусад зардал	15	(111,750)	(159,896)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын олз/(гарз)	12	(255,293)	(112,215)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)	13	450,021	(200,400)
Нийт үйл ажиллагааны зардал		(1,677,012)	(2,037,485)
Татварын өмнөх ашиг		9,122,514	8,520,100
Орлогын албан татварын зардал	16	(2,250)	(129,256)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ		9,120,264	8,390,844
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	21	501,346	(685,813)
НИЙТ БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		9,621,610	7,705,031
Нэгж эрхийн тоо	20	50,000,000	50,000,000
Нэгж эрхэд ногдох суурь ашиг (төгрөгөөр)		182	168

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тодруулга	2025-12-31	2024-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	17	-	208,021
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	17	1,762,897	8,166,763
Нийт эргэлтийн бус хөрөнгө		1,762,897	8,374,784
Эргэлтийн хөрөнгө			
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	17	13,545,704	27,709,577
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	17	61,623,944	31,688,554
Бусад авлага	19	1,490,279	1,083,513
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18	7,431	2,070,041
Нийт эргэлтийн хөрөнгө		76,667,358	62,551,685
НИЙТ ХӨРӨНГӨ		78,430,255	70,926,469
ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Нэгж эрх	20	50,000,000	50,000,000
Бусад нөөц	21	224,898	(276,448)
Хуримтлагдсан ашиг		27,127,505	18,066,719
НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ		77,352,403	67,790,271
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өглөг	22	1,077,852	3,136,198
Нийт богино хугацаат өр төлбөр		1,077,852	3,136,198
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		78,430,255	70,926,469

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Нэгж эрх	Хуримтлагдсан ашиг	Бусад нөөц	Нийт цэвэр хөрөнгө
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000,000	9,669,518	409,365	60,078,883
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(49,486)	-	(49,486)
2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	50,000,000	9,620,032	409,365	60,029,397
Тайлант жилийн ашиг	-	8,390,844	(685,813)	7,705,031
Бусад дэлгэрэнгүй орлого	-	55,843	-	55,843
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000,000	18,066,719	(276,448)	67,790,271
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	50,000,000	18,066,719	(276,448)	67,790,271
Тайлант жилийн ашиг	-	9,120,264	501,346	9,621,610
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(59,478)	-	(59,478)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000,000	27,127,505	224,898	77,352,403

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	9,122,514	8,520,100
Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус тохируулга:		
Хүүгийн орлого	(9,126,542)	(7,806,115)
Ногдол ашгийн орлого	(2,507,687)	(1,509,205)
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз/гарз	(580,414)	(308,176)
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны (олз)/гарз	534,910	(1,104,430)
БДОБУЦ-ээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн (олз)/гарз	555,086	(51,058)
Үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,002,133)	(2,258,884)
Ажлын капиталын өөрчлөлт:		
Хорогдуулсан өртгөөрх бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт)	13,836,985	(5,107,025)
БДОБУЦ-ээрх бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт)	(24,086,611)	(3,754,264)
Санхүүгийн хөрөнгийн бодит бус олз/гарз	439,618	690,351
Бусад авлагын (өсөлт)/бууралт	(849,653)	241,482
Хойшлогдсон татварын хөрөнгийн (өсөлт)/бууралт	-	89,376
Бусад өглөгийн (бууралт)/өсөлт	(2,058,346)	2,946,252
Татвар болон хүүгийн зардлын өмнөх үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,720,140)	(7,152,712)
Төлсөн албан татвар	(2,250)	(129,256)
Хүлээн авсан хүүгийн орлого	10,021,700	7,212,644
Хүлээн авсан ногдол ашиг	2,507,687	1,509,205
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,193,003)	1,439,881
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дэх гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	130,393	508,576
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	(2,062,610)	1,948,457
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,070,041	121,584
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,431	2,070,041

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1. Сангийн ерөнхий мэдээлэл

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК (цаашид "ХОС" гэх) нь хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2021 оны 04-р сарын 07-ны өдрийн үүсгэн байгуулагчийн №01 тоот шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2021 оны 05-р сарын 18-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6702988 тоот регистр бүхий 9011827609 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 08 сарын 18-ны өдрийн 328 дугаар тогтоолоор Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 312/02 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан байна. Хөрөнгө оруулагчдадаа урт хугацаанд, тогтвортой, өндөр өгөөжийг хүртээж ажиллахыг эрхэмлэдэг. Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй системийн нөлөө бүхий банк болон мөнгөний зах зээлд хөрөнгө оруулалт хийх замаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол өсгөх зорилготой.

Сангийн нэгж эрхийг шууд эсвэл хоёрдогч зах зээл дээрээс өөрийн хууль ёсны өмчлөлд шилжүүлэн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлд бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийг нэгж эрх эзэмшигч (Сангийн нэгж эрх эзэмшигч) гэж үзнэ.

Сан нь 10 жил үйл ажиллагаагаа явуулах бөгөөд үйл ажиллагаа дуусгавар болсны дараа нийт хөрөнгөө хөрөнгө оруулагчиддаа хуваарилна.

Сан нь банкны хадгаламж, хувьцаа, тогтмол орлоготой үнэт цаасанд хөрөнгө оруулж, урт хугацаанд тогтвортой, өндөр өгөөжийг бий болгон Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөх үйл ажиллагаа эрхэлдэг.

Сан нь Хөрөнгө Оруулалтын Сангийн тухай хуулиар ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд "Мандал Ассет Менежмент" ХХК нь (цаашид ХОМК) Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гол удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээдэг.

"Голомт Банк" ХК-ийн кастодиан үйлчилгээний хэлтэс нь сангийн кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцоог зааварчилгааны дагуу гүйцэтгэх, хөрөнгийн үнэлгээг тооцох, тайлан мэдээллээр хангах болон нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээ үзүүлдэг.

Сангийн бүртгэгдсэн албан ёсны хаяг, байршил нь: Жамъян гүний гудамж, Мөрү тауэр, 602 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс.

Төлөөлөн Удирдах Зөвлөл:

№	Овог Нэр	Үүрэг, хариуцлага
1	Н.Монсор	Дарга
2	Ч.Анхбаяр	Гишүүн
3	Ц.Батсүх	Гишүүн
4	Ж.Дэлгэрсайхан	Гишүүн
5	Р.Сугархүү	Гишүүн

2. Сангийн үйл ажиллагаа явуулж буй орчин

2.1. Ерөнхий

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт тулгуурласан хэвээр байгаа бөгөөд нүүрс, зэсийн экспорт эдийн засагт голлох нөлөө үзүүлж байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2025 онд ойролцоогоор 6.0% - 6.3% орчим байсан бөгөөд энэхүү өсөлтийг улсын хэмжээнд зэсийн үйлдвэрлэл нэмэгдсэн болон хөдөө аж ахуйн салбарын эргэн сэргэлттэй холбон тайлбарлаж болохоор байна. Дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөвийг ерөнхийд нь тогтвортой гэж үнэлж байгаа боловч дэлхийн худалдааны бодлогын өөрчлөлтөөс үүдэлтэй шууд бус нөлөөлөл зэрэг тодорхой эрсдэл, тодорхойгүй байдал 2025 ондоо үргэлжилсэн болно.

ОХУ болон Украины дайн нь олон улсын худалдаа, эрчим хүчний зах зээлд нөлөөлсөөр байгаа бол Израиль-Газын мөргөлдөөн нь дэлхийн эдийн засагт, ялангуяа газрын тосны үнэд тодорхойгүй байдлыг бий болгож байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын инфляци, санхүүгийн зах зээл, эдийн засгийн ерөнхий төлөвт нөлөөлж болзошгүй.

Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) асуудал бизнесийн орчинд улам бүр чухал байр суурь эзлэх боллоо. Монгол Улс эдийн засгийн олон талт хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх зорилт тавьж байгаа бөгөөд уул уурхайн салбарын компаниудад ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлага нэмэгдэж байна. Олон улсын хөрөнгө оруулагчдын хүлээлт, зохицуулалтын шинэ шаардлагуудын хүрээнд ESG-тэй уялдсан бизнесийн загварыг хэрэгжүүлэх нь зайлшгүй болж байна.

Удирдлага нь Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

2.2. Валютын арилжаа

Үндсэн гадаад валют болох Ам.доллар болон Евро зэрэг нь Монгол Улсын ихэнх бизнесийн төлбөр тооцоонд ашиглагдаж, суурь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Доорх хүснэгт нь Монгол Улсын Төв Банкнаас зарласан Ам.доллар болон Еврогийн Төгрөгтэй харьцах ханшийг харуулав.

Огноо	Ам.доллар	Евро
2025 оны 12 сарын 31	3,556.66	4,186.72
2024 оны 12 сарын 31	3,420.25	3,566.98

2.3 Бүртгэлийн болон тайлагналын валют

Сангийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчны үндсэн мөнгөн тэмдэгт байна. Сангийн бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг ("ТӨГ") юм. Эдгээр санхүүгийн тайлангуудад өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянганчлан илэрхийлэгдсэн.

3. Тайлан бэлтгэх үндэслэл

3.1 Ерөнхий зарчмууд

Сангийн эдгээр санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу түүхэн бодит үнэ цэнд үндэслэн санхүүгийн хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөр өөрчлөгдсөн бодит үнэ цэнээр ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (“ААБҮЦ”)-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүр болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (“БДОБҮЦ”)-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүрээр бүртгэх зарчмыг баримтлан бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг Тодруулга 4-т толилуулав. 2025 оны 8 сарын 7-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж буй хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон нягтлан бодох бүртгэлийн бодлогоос бусад нь өөрөөр заагаагүй бол бүх тайлант жилүүдэд тасралтгүй мөрдөгдөж ирсэн Тодруулга 5-аас харна уу.

Сан нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Эдгээр санхүүгийн тайлангууд нь СТОУС-тай бүх материаллаг зүйлсийн хувьд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн суурийн дагуу бэлтгэгдсэн. Тодруулга 4-т эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг туслав.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж

Сан эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөх дүнд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд нөлөөлөх тооцоолол болон таамаглалыг хийдэг. Удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх тухайн нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт зэрэг бусад хүчин зүйлүүдэд үндэслэдэг чухал тооцоолол дүгнэлтүүд нь байнга дахин хянагдаж байдаг. Удирдлага мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэглэхдээ тооцооллоос гадна тодорхой дүгнэлтийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт. ХБЭА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна. ХБЭА-ын хэмжилтийн арга зүйн дэлгэрэнгүйг Тодруулга 23-аас харна уу.

Эрсдэлийн алдагдлын хасагдуулгад дараах бүрэлдэхүүн үзүүлэлтүүд чухал нөлөөтэй: төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолт, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR), төлбөр төлөгдөхгүй байх магадлал (PD), төлөгдөөгүй үлдсэн үлдэгдэл (EAD), төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлээс үүсэх алдагдал (LGD), мөн макро эдийн засгийн хувилбарын загвар.

Сан хорогдуулсан өртөг болон БДОБҮЦ-ээр ангилагдсан бүх өрийн хэрэглүүрүүдийн хувьд ХБЭА-ыг тооцоолдог бөгөөд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол болон бодит эрсдэлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах загварууд болон түүнд ашиглагдах өгөгдлүүдийг байнга хянаж баталгаажуулдаг.

Сан ХБЭА-ыг тооцоолох үедээ зэрэглэл тогтоох олон улсын үнэлгээний байгууллагуудын зээлжих зэрэглэлтийн үнэлгээнд үндэслэн хялбаршуулсан арга зүйг ашигладаг. Төлбөр төлөгдөхгүй байх магадлалын зэрэглэлийг тодорхойлох судалгаанд тулгуурлан харилцагч талын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд ирээдүйд чиглэсэн мэдээллийг оруулсан гэж удирдлага үзэж байгаа болно.

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт ("SICR"). Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Сан тайлант жилийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна.

Үнэлгээгээр тайлант жилийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Сан бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйг харсан мэдээллийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг. Тодруулга 23-аас харна уу.

Бизнес загварын үнэлгээ. Бизнес загварт үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэглүүрүүдийн багц болон ижил байдлын түвшинг тодорхойлохдоо үнэлэлт өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ Сан нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Хэрэв "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК (цаашид "Сан" гэх) бодит үнэ цэнээр илэрхийлэх сонголтыг ашиглан энэ ангилалд санхүүгийн хөрөнгийг ангилах шийдвэр гаргасан бол цаашид уг хөрөнгийн ангиллыг өөрчлөхгүй.

Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилготой бизнесийн загвар нь санхүүгийн хөрөнгийг дуусвар хугацаа хүртэл эзэмших нөхцөлд тохиолддог. Компанийн хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд Компанийн зүгээс таамаглах боломжгүй байдаг. Мөн зээл чанаргүйдсэнээс үүсэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ болон зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх бага давтамжтай, үнийн дүн багатай борлуулалтын үед ч тухайн санхүүгийн хөрөнгө "Цуглуулах зорилготой бизнесийн загвар"-т нийцсэн хэвээр байж болох юм.

"Цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших" бизнес загвар нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь мөн энэхүү бизнес загварын зорилгыг биелүүлэхэд чухал юм. Үүнд хөрвөх чадвартай байдлаа удирдахын тулд тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулахын тулд гэх мэт.

Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ ("ЗХҮТ")

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс ("ЗХҮТ") бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элемент нь өөрчлөгдөх магадлалтай, жишээ нь хэрэв гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэглүүрүүдийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй байдаг. Өөрчлөгдсөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэглүүртэй харьцуулалт хийх байдлаар үнэлэх бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрд болон хэрэглүүрийн хугацааны туршид хуримтлуулан тооцно. Үнэлгээ хамгийн боломжит бүх тохиолдолд хийгдсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдол болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд ч мөн хийгдсэн байна.

3. Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

Холбоотой талын ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлт

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Сан холбогдох талуудтай ажил гүйлгээнд оролцдог. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнд суурилан анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэхийг шаарддаг. Энэхүү ажил гүйлгээг зах зээлийн эсвэл зах зээлийн бус (өөрөөр хэлбэл энэхүү ажил гүйлгээтэй холбоотой идэвхтэй зах зээл байхгүй) хүүтэй уялдсан эсэхийг тодорхойлоход үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээнд өөр бусад хамааралгүй этгээдтэй хийсэн ижил төрлийн ажил гүйлгээний үнийн дүн болон үр ашигт хүүгийн шинжилгээг ерөнхий зарчим болгодог. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний нөхцөл болон дансны үлдэгдлийг Тодруулга 7-д тусгасныг харна уу.

Мэргэжлийн шийдэл

Мэдэгдэхүйц мэргэжлийн шийдэл болон тооцоолол ашигласан хөрөнгө, өр төлбөрийн зүйлс дараах байдалтай байгаа бөгөөд холбогдох тодруулгуудад дэлгэрэнгүй тодруулсан.

Санхүүгийн хэрэглүүрийн хувьд:

- Идэвхитэй зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг үнэлгээний өдрийн биржийн арилжаа хаах үеийн зах зээлийн үнэд үндэслэн тооцоолдог.
- Идэвхитэй зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тооцохдоо ижил төстэй хөрөнгийн идэвхитэй бус зах зээлийн жишиг үнэ, нөхцөлт өөрчлөлт, зээлийн тархалт, гэрээний хүүгийн түвшин болон жишиг ашиглаж болохуйц хүүгийн түвшин, үнэлгээний арга зүй болон үл үндэслэлтэй байж болох зүйлсийг харгалзан үздэг.

Хяналт болон мэдэгдэхүйц нөлөөллийг тогтооход ашигласан мэргэжлийн шийдэл- Сангийн үндсэн зорилго хөрөнгө оруулалтаас хүртэх өгөөжийг өндөр байлгах бөгөөд дийлэнхи тохиолдолд өмчийн хэрэглүүрийг худалдан борлуулах зорилготой учир хяналт хэрэгжүүлэхгүй гэсэн төсөөлөл, таамаглал ашигладаг. Ажил гүйлгээний үзүүлэх үр нөлөө, холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил шинж чанартай ажил гүйлгээнээс ялгаатай болон төсөөтэй талуудыг харгалзан үздэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Сангийн эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант хугацаануудад тууштай мөрдөж хэрэгжүүлсэн болно.

4.1. Тасралтгүй байх зарчим

Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэсэн. Сангийн санхүүгийн мэдээллийг ойрын ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн таамаглалд тулгуурлан бэлтгэсэн бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байх хугацаанд хөрөнгө орлогоо бодитой хэрэгжүүлж, өр төлбөр, амлалтаа биелүүлэх боломжтой байх болно гэж үзсэн.

4.2. Гадаад валютын ханшийн хөрвүүлэлт

Эдгээр санхүүгийн тайлангууд Сангийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох Монгол Төгрөг ("ТӨГ")-өөр илэрхийлэгдсэн болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.3. Ажил гүйлгээнүүд болон үлдэгдэл дүнгүүд

Гадаад валютаарх мөнгөөр солигдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг Сангийн бүртгэлийн валют руу тухайн тайлангалын эцсийн өдрийн Монголбанк ("МБ")-ны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөөрх хөрөнгө ба өр төлбөрийг Сангийн бүртгэлийн валют руу тайлан тэнцлийн өдрийн МБ-ны жилийн эцсийн албан ханш руу хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд "санхүүгийн орлого, зардал"-аар тогилуулна. Бусад бүх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд "Гадаад валютын ханшийн олз/гарз, цэвэр дүн"-ээр тогилуулна. Жилийн эцсийн ханшаарх хөрвүүлэлт нь түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд хамаарахгүй. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлийг, түүний дотор өмчийн хөрөнгө оруулалтыг, бодит үнэ цэнийг нь тодорхойлсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлдэг. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлс дэх валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөг бодит үнэ цэнийн олз эсвэл гарзын нэг хэсэг болгон бүртгэдэг.

4.4. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Элэгдэл, хорогдуулалт тооцдог хөрөнгийг өөрийн дансны үнээ нөхөх боломжгүйг илтгэж буй үйл явдал, нөхцөл байдлын өөрчлөлт бүрд түүний үнэ цэнийн бууралтыг хянаж үздэг. Үнэ цэнийн бууралтын гарзыг бүртгэхдээ тус хөрөнгийн дансны үнийн нөхөгдөх дүнгээс давсан дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь хөрөнгийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байна. Үнэ цэнийн бууралтыг үнэлэхийн тулд хөрөнгийг түүний бие даасан бэлэн мөнгөний урсгалд (мөнгө бий болгогч нэгж) хамгийн бага тодорхойлж болохуйц үнийн түвшинд нэгтгэдэг.

4.5. Санхүүгийн хэрэглүүр - хэмжилтийн үндсэн нөхцөл

Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас хамааран дараах байдлаар бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Бодит үнэ цэнэ гэж хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө худалдсан бол хүлээн авах буюу өр төлбөр шилжүүлсэн бол төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхитэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг. Идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь сангийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэнд нөлөөлөх тохиолдол байдаг.

Гүйлгээний зардал нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч (мөн борлуулалтын агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөхүүд, брокерууд болон дилерүүдэд төлсөн шимтгэл, хураамж, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөр, шилжүүлгийн татвар, хураамж хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэл эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, захиргааны дотоод зардал, хадгалалтын зардал орохгүй.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.5. Санхүүгийн хэрэглүүр - хэмжилтийн үндсэн нөхцөл (үргэлжлэл)

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгана.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид бүртгэлийн дүнгээс тооцогдох хүүгийн хувь (үр ашигт хүү)-ийг тогтмол байлгахаар хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтчилж, санхүүгийн хэрэглүүрийн бүртгэлийн нийт дүнг гаргаж авах хүүгийн хувь болно.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөгч хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй ба бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоолонд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах ба тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдан авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралт хийгдсэн зээл ("POCI") -ийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүний түвшинг зээлийн эрсдэлд тохируулахыг хэлнэ. Үүнд анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

4.6. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн хэрэглүүрүүд нь анхлан гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Анхлан хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнэ нь гүйлгээний дүнгээр хамгийн сайн нотлогдоно. Анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний дүнгийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийн идэвхтэй зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн идэвхтэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэх болно. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа ХБЭА-ын нөөц сан нь хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрдөг ба өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж гарсан үр дүн нь шууд бүртгэлийн гарз болдог.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Сан тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Сан санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

4.7. Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт- хэмжилтийн төрөл

Сан нь санхүүгийн хөрөнгүүдийг дараах хэмжилтийн төрлүүдээр ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ("ААБҮЦ"), Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ("БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Сангийн бизнес загвар (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.8. Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт- бизнес загвар

Бизнес загвар нь Сан хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Сангийн зорилго нь:

- Зөвхөн хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших),
- Хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших),
- Хэрэв 1 ба 2-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь “бусад” гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Сангийн гүйцэтгэж буй үйл ажиллагаануудад хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Сангийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлага зэргийг авч үздэг.

4.9. Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог

Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр (ЗҮХТ)-өөс бүрдэж буй эсэхэд Сан үнэлгээ өгдөг. Тэдгээрийн мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ Сан гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх өөрчлөлтийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэж ангилагдана. ЗҮХТ-ийн үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа хийгдэхгүй.

4.10. Санхүүгийн хөрөнгө - дахин ангилал

Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ.

4.11. Санхүүгийн хөрөнгө – үл хүлээн зөвшөөрөлт

Сан санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож;

- хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн эсвэл
- хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй.

Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч талд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.12. Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөөлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд:

- (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед
- (ii) төлбөр төлөгдөхгүй болох үед
- (iii) төлбөрийн чадваргүй болж дампуурсан үед бий болдог.

4.13. Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Сан санхүүгийн хөрөнгийн нөхөн төлөгдөх үйл ажиллагаа дуусгавар болсон, дахин нөхөн сэргээх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Сан гэрээний дагуу төлөгдөх дүнг шаардан авах эрхтэй боловч буцаан олгох магадлал бага үед хууль сахиулах үйл ажиллагаа дуусаагүй зарим санхүүгийн хөрөнгүүдийг данснаас хасдаг.

4.14. Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бизнес загвар болон мөнгөн гүйлгээний шинж чанарт үндэслэн, Сан өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэж ангилдаг. Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан ЗХҮТ-ийн мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор болон нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахын тулд бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийг нь сайн дураар хүлээн зөвшөөрөөгүй үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй бол бусад орлогоор хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Тухайн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж ашиг, тооцоолсон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дансны үнэ дэх бусад бүх өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг бүртгэлээс хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг алдагдал руу дахин ангилдаг.

Хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ.

Сан нягтлан бодох бүртгэлийн олон янзын сууриар хүлээн зөвшөөрөгдсөн буюу хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хоорондын нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахад анхны хүлээн зөвшөөрөлтөөр Сангийн ААБҮЦ-ээрх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дахин тодорхойлж болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.15. Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагчийн хэтийн төлөвт өмчийн тодорхойлолтыг хангасан санхүүгийн хөрөнгө (жишээ нь, мөнгөөр төлөх гэрээний үүргийг агуулаагүй санхүүгийн хэрэглүүр ба гаргагчийн цэвэр хөрөнгөнд үлдэх хувь оролцоог нотлох баримт) нь Сангийн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг илтгэнэ. Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөхөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжинэ. Сангийн бодлогоор хөрөнгө оруулалтын өгөөж бий болгохоос бусад стратегийн зорилгоор хөрөнгө оруулалтыг эзэмшдэг бол өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж тодорхойлдог. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх сонголтын үед, бодит үнэ цэнийн олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, цаашид болон түүнийг борлуулсан үед ашиг, алдагдалд дахин ангилж бүртгэхгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз ба тэдгээрийн буцаалт байгаа тохиолдолд бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Сангийн төлбөр хүлээн авах эрх нь ийм хөрөнгө оруулалтын өгөөж гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд ногдол ашгийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

4.16. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах хадгаламжийн мөнгө, 3 сар болон түүнээс богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай бусад богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг анх бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр толилуулна. Учир нь:

- (i) тэдгээр нь гэрээний мөнгөн урсгалаас цуглуулагдан эзэмшиж байгаа болон тэдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮХТ-ийг тусгасан байдаг болон
- (ii) тэдгээр нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй байдаг.

4.17. Бусад авлага

Дансны ба бусад авлагуудыг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба цаашдаа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Авлагын хорогдуулсан өртөг гэж анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс эргэн төлөлт болон эрсдэлийн санг хассан цэвэр дүнг хэлнэ.

4.18. Бусад өглөг

Дансны болон бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба анхлан бодит үнэ цэнээр, цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Нэгж эрхийг барагдуулахаар үүссэн өр төлбөрийг шилжүүлэн бүртгэсэн өдрийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр өр төлбөрийг хэмжиж үнэлнэ.

4.19. Санхүүгийн өр төлбөр

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө. Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Сангийн санхүүгийн өр төлбөрт бусад өр төлбөр болон холбоотой талын өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрийг зээл ба зээллэг гэж ангилдаг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.19. Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

4.20. Орлогын албан татвар

Орлогын албан татвар нь санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн дагуу хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. Санхүүгийн тайланг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоонд үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх үед хойшлогдсон орлогын албан татварыг тооцохдоо тайлан тэнцлийн өглөгийн аргыг ашиглах ба хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн дүн болон татварын суурийн хоорондын түр зөрүүг тайлант хугацаанд тооцож бүртгэдэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татвар бүртгэгддэггүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг.

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасаж ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хаахдаа хуулиар хооронд нь хааж болох эрх үүссэн, тухайн хуулийн этгээд эсвэл цэвэр дүнгээр тооцох сонирхол бүхий хэд хэдэн хуулийн этгээдийн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр болон орлогын албан татварыг хураан авах эрх бүхий татварын байгууллага нь ижил байгаа эсэхийг авч үзнэ.

Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг чөлөөлөхөөр заасан байдаг тул сан нь хөрөнгө удирдах явцад үүсэж буй үйл ажиллагааны орлогод хойшлогдсон татварын нөлөөлөл тооцох шаардлагагүй байдаг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.21. Урьдчилж төлсөн тооцоо

Урьдчилгаа төлбөрийг өртгөөр нь буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж, бүртгэнэ. Урьдчилж төлсөн тооцоонд түр хугацаагаар байршуулсан барьцаа хөрөнгө, дэнчин болон бусдаас авах бараа, ажил, үйлчилгээний үнэнд төлсөн урьдчилгаа төлбөрийг бүртгэнэ. Үнэт цаасны арилжааны төлбөрийг хийснээр, барьцаа хөрөнгө болон дэнчинд тавьсан хөрөнгөө эргүүлэн авахад холбогдох урьдчилж төлсөн тооцооны дансыг кредитлэнэ.

4.22. Цэвэр хөрөнгө

Гаргасан нэгж эрхийг эздийн өмчид тусгана. Сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан байна.

4.23. Ногдол ашиг

Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эзэмшиж буй нэгж эрхийн тоонд суурилж харилцан адилгүй байна. Тайлант хугацааны эцэст хуримтлагдсан ашгийн данснаас Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараах эсхүл Сангийн нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгөнд хуваарилах шийдвэрийг дүрэмд заасны дагуу ТУЗ гаргана. Сангийн хувьд үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу Сангийн орлогоор ногдол ашиг хуваарилахгүй байж болно.

4.24. Болзошгүй өр төлбөрт зориулсан нөөц

Өр төлбөрийн нөөц гэж тодорхой төлөгдөх хугацаа болон үнийн дүнгүй санхүүгийн бус шинжтэй өр төлбөрийг хэлнэ. Сан урьд нь тохиолдсон үйл явдлын үр дүнд өнөөгийн (эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг биелүүлэхэд шаардагдах эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг гарган өгөх магадлалтай мөн уг үүргийн дүнг үндэслэлтэйгээр тооцоолох боломжтой тохиолдолд нөөц санг байгуулдаг. Тухайн үүрэгтэй холбоотой эрсдэлүүд болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнээр тооцсон өнөөгийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувиар тооцсон өгөлгийг барагдуулахад шаардлагатай зарлагын өнөөгийн үнэ цэнийг хэмжиж нөөц санг байгуулдаг. Цаг хугацааны хүчин зүйлээс шалтгаалж өссөн нөөцийн хэмжээг хүүгийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

4.25. Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг аккрузал суурыг үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талууд хоорондын гэрээний дагуу хүлээн авсан бүх хураамж болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүгийн тооцоолонд оруулан тооцож, хугацааны хувьд хойшлуулсан хүүгийн орлого болгон бүртгэдэг. Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотой.

Үүссэн болон худалдан авсан, эрсдэлийн үнэ цэнэ бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд анхны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал орно) анх бодит үнэ цэнээр нь (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө дискаунтчлах хүү юм. Үүний үр дүнд үр ашигт хүүгийн түвшин нь эрсдэлийн тохируулгатай байдаг.

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.25. Хүүгийн орлого (үргэлжлэл)

Хүүгийн орлогыг доорхоос бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны нийт үнээс үр ашигт хүүний түвшингээр тооцоолно:

- (i) санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтанд орсон (3-р шатлал) бол хүүгийн орлогыг тооцохдоо хорогдуулсан өртгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээс үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцоолно,
- (ii) худалдан авсан эсвэл анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд тохируулагдсан үр ашигт хүүгийн түвшинг хорогдуулсан өртгөөр тооцоолно.

5. Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт

Дараах нэмэлт өөрчлөлт оруулсан стандартууд 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Компани эдгээр стандартуудыг холбогдох тохиолдолд мөрдөн ажилласан.

	Тайлбар	Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
• НББОУС 21	<i>Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө</i>	2023 оны 8 сар	2025 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: Валют солилцох боломжгүй нөхцөл байдалтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд. Эдгээр өөрчлөлт нь валютыг хэзээ солилцох боломжтой гэж үзэх болон боломжгүй тохиолдолд ханшийг хэрхэн тодорхойлох талаар удирдамж өгсөн.		
• ТБНББСЗ	<i>Гол өөрчлөлт ба анхаарах асуудал:</i>	2023 оны 12 сар	2025 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB). Эдгээр өөрчлөлт нь салбар, сэдэв, хэмжүүрүүдийг үндсэндээ өөрчлөхгүйгээр, тухайн улсын онцлогт хамаарах лавлагаа, тодорхойлолтуудыг хасаж, орлуулсан.		

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд

Сангийн санхүүгийн тайлангуудыг батлаж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан ба хараахан хэрэгжиж эхлээгүй стандартууд болон тайлбаруудын жагсаалтыг дор үзүүлэв. Сан энэхүү стандартуудыг шаардлагатай тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

	Тайлбар	Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
СТОУС 7 ба СТОУС 9	Санхүүгийн хэрэгсэл: Ангилал ба хэмжилт Гол өөрчлөлт болон асуудлууд: Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 9 Санхүүгийн хэрэгслийн ангилал, хэмжилтийн шаардлагын хэрэгжилтийн дараах үнэлгээний үеэр тодорхойлогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.	2024 оны 5 сар	2026 оны 1 дүгээр сарын 1
СТОУС 7 ба СТОУС 9	Санхүүгийн хэрэгсэл: Худалдан авалтын зохицуулалт Гол өөрчлөлт болон асуудлууд: Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: Байгаль, цаг уурын нөхцлөөс хамааралтай цахилгаан эрчим хүчтэй холбоотой гэрээг санхүүгийн тайланд илүү бодитойгоор тусгах мэдээллийг оруулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.	2024 оны 7 сар	2026 оны 1 дүгээр сарын 1
Нягтлан бодох бүртгэлийн стандартын жилийн сайжруулалт	Дараах стандартуудад нэмэлт өөрчлөлт орсон: • СТОУС 1: Анх удаа хэрэгжүүлэгчийн хеджийн нягтлан бодох бүртгэл • СТОУС 7: Санхүүгийн хэрэгслийг данснаас хасах үед үүсэх ашиг, алдагдал • СТОУС 7: Шударга үнэ ба гүйлгээний үнийн хоорондын хойшлогдсон зөрүүний ил тод байдал • СТОУС 7: Танилцуулга ба зээлийн эрсдэлийн ил тод байдал • СТОУС 9: Түрээслэгчийн түрээсийн өр төлбөрийг данснаас хасах • СТОУС 9: Гүйлгээний үнэ • СТОУС 10: “Бодит агент”-ыг тодорхойлох • НББОУС 7: Зардлын арга	2024 оны 12 сар	2026 оны 1 дүгээр сарын 1

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд (үргэлжлэл)

Тайлбар		Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
• СТОУС 18	Санхүүгийн тайлангийн танилцуулга ба ил тод байдал	2024 оны 4 сар	2027 оны 1 дүгээр сарын 1
• Гол өөрчлөлт болон асуудлууд	Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 18 нь СТОУС хэрэглэж буй бүх аж ахуйн нэгжид хамаарах санхүүгийн тайлангийн мэдээллийг танилцуулах болон ил тод болгох шаардлагуудыг агуулна.		
• СТОУС 19	Нийтийн хариуцлагагүй охин компаниуд: Ил тод байдал	2024 оны 5 сар	2027 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 19 нь нийтийн хариуцлагагүй, шаардлага хангасан охин компаниуд бусад СТОУС стандартын оронд мөрдөж болох ил тод байдлын шаардлагуудыг тодорхойлсон.		

Дээр дурдсанаас өөрөөр тайлбарлаагүй тохиолдолд шинэ стандарт болон өөрчлөлтүүд Сангийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлэхгүй гэж таамаглаж байна.

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

7. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба дансны үлдэгдлүүд

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу "Холбоотой Талын Тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн Сан нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалт хамаарлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үздэг.

Нэгж эрх эзэмшигчид:	Нэгж эрхийн тоо
Тэнгэр Даатгал ХК	4,173,523
Мандал Ассет Менежмент ХХК	2,612,052
Мандал Даатгал ХК	2,632,112
Худалдаа Хөгжлийн Банк ХК	2,950,383
Бусад хувьцаа эзэмшигчид	37,631,930

ТУЗ-ийн гишүүд

Н.Монсор	МУ-ын иргэн	ТУЗ-ийн дарга
Ч.Анхбаяр	МУ-ын иргэн	Гишүүн
Ц.Батсүх	МУ-ын иргэн	Гишүүн
Ж.Дэлгэрсайхан	МУ-ын иргэн	Гишүүн
Р.Сугархүү	МУ-ын иргэн	Гишүүн

Хувь Хүн

Н.Болор-Эрдэнэ	МУ-ын иргэн	Гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн төлөөлөгч
Г.Ганзориг	МУ-ын иргэн	Гүйцэтгэх захирал

№	Нэр	Бүртгэлтэй улс	Төрөл	Холбоо хамаарал
ХОМК-ийн толгой компанийн охин компаниуд:				
1	Мандал Ассет Менежмент ХХК	Монгол Улс	27121	Охин Компани
2	Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК	Монгол Улс	27121	Охин Компани
3	Мандал Даатгал ХК	Монгол Улс	27121	Охин Компани
4	Мандал Дижитал Кредит ББСБ ХХК	Монгол Улс	27121	Охин Компани
5	Мандал Лайф Даатгал ХХК	Монгол Улс	27121	Охин Компани
6	Тэнгэр Даатгал ХК	Монгол Улс	27121	Охин Компани

Холбоотой талын мэдээллийг удирдлагын бэлтгэсэн мэдээлэл болон олон нийтэд нээлттэй мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн бөгөөд тодруулагдаагүй холбоотой тал байж болзошгүй.

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

7. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба дансны үлдэгдэлүүд (үргэлжлэл)

Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх холбоотой талуудын үлдэгдэл дүнгүүдийг дор үзүүлэв.

(Мянган төгрөгөөр)	Нэгж эрх эзэмшигчид	Бусад холбоотой тал	Нийт дүн
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	2,229,570	-	2,229,570
Дансны болон бусад өглөг	1,029,901	-	1,029,901

Компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх холбоотой талуудын үлдэгдэл дүнгүүдийг дор үзүүлэв.

(Мянган төгрөгөөр)	Нэгж эрх эзэмшигчид	Бусад холбоотой тал	Нийт дүн
Дансны болон бусад авлага	58,677	-	58,677

Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн холбоотой талуудтай хийсэн орлого болон зардлыг дор харуулав.

(Мянган төгрөгөөр)	Нэгж эрх эзэмшигчид	Бусад холбоотой тал	Нийт дүн
Менежментийн зардал	1,687,472	-	1,687,472
Захиргааны болон үйл ажиллагааны бусад зардал	2,798	-	2,798

Компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн холбоотой талуудтай хийсэн орлого болон зардлыг дор харуулав.

(Мянган төгрөгөөр)	Нэгж эрх эзэмшигчид	Бусад холбоотой тал	Нийт дүн
Менежментийн зардал	1,146,733	-	1,146,733

ХОС нь хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу ажилтан авч ажиллуулахгүй байхаар зохицуулагдсан байдаг ба Мандал Ассет Менежмент ХХК нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гол удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээдэг. Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд дор дурдсан цалин урамшуулал тооцож олгосон.

Эрх бүхий албан тушаалтнуудын цалин хөлс, нөхөн олговорын талаарх мэдээллийн дор тусган харуулав.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Цалин хөлс	19,500	-
Нийгмийн даатгал	2,340	-

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

8. Хууль дүрэм журам нийцэл

Санхүүгийн Зохицуулах Хорооны "Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам"-ын хүрээнд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байх ёстой, тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн хувьцаа, нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээш хувийг эзэмшихгүй байх бөгөөд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулж болно гэх бүх шаардлагудыг хангаж ажилласан байна.

9. Хүүгийн орлого

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хүүгийн орлогын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого:		
Компанийн бондын хүүгийн орлого	6,668,775	2,340,675
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн орлого	993,010	1,503,118
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого:		
Засгийн газрын бондын хүүгийн орлого	42,560	189,417
Хадгаламжийн хүүгийн орлого	1,422,197	3,772,905
Нийт хүүгийн орлого	9,126,542	7,806,115

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хүүгийн орлогыг үнэт цаас гаргагч компаниар нь ангилбал дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Үнэт цаас гаргасан компани:		
Нэткапитал Санхүүгийн Групп	2,004,866	132,890
Ашид Капитал ББСБ ХХК	1,417,391	930,390
Жемтрейд ХХК	780,012	-
Бичил Глобус Санхүүгийн Нэгдэл	656,227	1,113,856
Инвескор ББСБ ХК	643,314	665,303
Омни Капитал ББСБ ХХК	595,043	422,759
Булл Капитал ББСБ ХХК	325,289	8,381
Голомт Банк ХК	319,381	-
Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК	272,517	-
Соно Финтек ББСБ ХХК	124,395	-
Мандал Дижитал Кредит ББСБ ХХК	120,843	-
Жи Эс Би Капитал ББСБ ХХК	108,900	8,137
Эко Кредит ББСБ ХХК	101,197	-
Бусад	192,410	562,077
Нийт БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогын дүн	7,661,785	3,843,793

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

9. Хүүгийн орлого (үргэлжлэл)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хадгаламж болон засгийн газрын бондын хүүгийн орлогыг харилцагч банкаар нь ангилбал дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Голомт Банк ХК	748,941	459,493
Худалдаа хөгжлийн Банк ХК	476,668	278,230
М Банк ХК	159,690	1,292,499
Хаан Банк ХК	21,890	1,598,565
Тээвэр Хөгжлийн Банк	12,502	7,504
Богд Банк ХК	2,493	136,563
Капитрон Банк ХК	13	51
Хадгаламжийн хүүгийн орлогын нийт дүн	1,422,197	3,772,905
Засгийн газрын бонд	42,560	189,417
Нийт хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогын дүн	1,464,757	3,962,322

10. Ногдол ашгийн орлого

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хүлээн авсан ногдол ашгийн орлогын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас хүлээн авсан ногдол ашиг	2,507,687	1,509,205
Нийт ногдол ашгийн орлогын дүн	2,507,687	1,509,205

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд хүлээн авсан ногдол ашгийн орлогыг үнэт цаас гаргагч компаниар нь ангилбал дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Хаан Банк ХК	1,682,872	594,543
Алу ХК	533,131	450,790
Төрийн Банк ХК	251,692	276,911
Голомт Банк ХК	39,992	133,335
Бусад	-	53,626
Нийт ногдол ашгийн орлогын дүн	2,507,687	1,509,205

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

11. Бусад орлого

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад орлогын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Бусад орлого	-	86,777
Нийт бусад орлогын дүн	-	86,777

Үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлсөн тул өмнөх жилүүдэд үүсгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийг 2024 онд бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

12. Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үүссэн олз, гарз

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үүссэн олз, гарзын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн арилжааны олз/(гарз)	(299,793)	1,104,430
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз/(гарз)	(534,910)	51,058
Нийт санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үүссэн олз, гарз	(834,703)	1,155,488

СТОУС 9-ийн дагуу компани хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын олз/(гарз) тооцоолон бүртгэж байгаа бөгөөд тайлант жилийн үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	(352,712)	(112,215)
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын олз	97,419	-
Нийт санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үүссэн үнэ цэнийн бууралтын олз, гарз	(255,293)	(112,215)

13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжсэн олз	1,149	32,744
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжсэн гарз	(131,542)	(541,320)
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз	724,680	479,038
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй гарз	(144,266)	(170,862)
Нийт гадаад валютын ханшийн зөрүүний гарзын дүн	450,021	(200,400)

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

14. Сангийн үйл ажиллагааны зардал

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
ХОМК-ийн үйлчилгээний зардал	724,495	631,976
Гүйцэтгэлийн урамшууллын зардал	962,977	870,504
Кастодиан банкны үйлчилгээний зардал	72,518	62,494
Нийт үйл ажиллагааны зардлын дүн	1,759,990	1,564,974

2021 оны 6 сарын 15-ны өдөр байгуулсан менежментийн гэрээний дагуу, Сан нь “Мандал Ассет Менежмент ХХК” (ХОМК)-иас менежментийн үйлчилгээ авах хөрөнгө оруулалтын менежерээр томилсон ба Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирддаг. Хөрөнгө оруулалтын менежер нь сангийн цэвэр хөрөнгө дүнгийн 1%-ийг үйлчилгээний төлбөр болгон сар бүр хүлээн авдаг.

ХОМК-д төлөх урамшуулал нь ХОМК-ийг урамшуулах зорилготой байх бөгөөд 12 сарын 31-нээр тасалбар болгосон 2025 оны нийт менежментийн үйлчилгээний урамшуулал нь 962.977 мянган төгрөг байна.

Сан нь Голомт Банк ХК-ний кастодиан үйлчилгээний хэлтсээс хөрөнгө хадгалах, төлбөр тооцоо гүйцэтгэх, нэгж эрхийн бүртгэл хөтлөх, үнэлгээ тооцоолох үйлчилгээ авдаг. Кастодиан банкинд үнэт цаас болон бусад хөрөнгийн дүнгийн 0.1%-тай тэнцүү үйлчилгээний хөлс төлдөг.

15. Бусад зардал

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад зардлын хураангуй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Үнэт цаасны арилжааны шимтгэл	36,746	66,312
Мэргэжлийн үйлчилгээний зардал	44,054	26,488
Цалин болон түүнтэй холбогдох зардал	21,840	-
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	4,504	1,000
Зар сурталчилгааны зардал	2,350	1,050
Банкны шимтгэлийн зардал	1,251	819
Бичиг хэргийн зардал	615	105
Бусад зардал	390	1,622
Торгууль, алдангийн зардал	-	62,500
Нийт бусад зардлын дүн	111,750	272,111

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

16. Орлогын албан татвар

16.1. Орлогын албан татварын зардал/(өгөөж)-ын бүрэлдэхүүн хэсэг

Ашиг, алдагдалд бүртгэсэн орлогын албан татварын зардал дараах зүйлсээс бүрдэнэ.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2025	2024
Тайлант жилийн орлогын албан татвар	2,250	129,256
Тайлант жилийн нийт орлогын албан татварын зардал	2,250	129,256

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд 2022 онд өөрчлөлт орж хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг 2024 оны 1 сарын 1-ээс аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр болсон. Өмнөх тайлант оны хүүгийн орлогоос хойшлогдсон татвар бүртгэсэн байсан ч тус онд зарим банкны хадгаламж татвар суутгахгүй шийдвэр гарсан байна.

17. Хөрөнгө оруулалт

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хөрөнгө оруулалтыг хэмжилтийн төрөл, ангиллаар харуулав.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2025-12-31	2024-12-31
Хөрөнгө оруулалтыг хэмжилтийн төрлөөр:		
Хорогдуулсан өртөг	13,545,704	27,817,598
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэн	63,386,841	39,855,317
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалтын дүн	76,932,545	67,772,915

Хөрөнгө оруулалтын төрлөөр:		
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	43,248,230	24,857,169
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	20,138,611	15,206,169
Банкинд байршуулсан хадгаламж	13,545,704	27,709,577
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалтын дүн	76,932,545	67,772,915

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2025-12-31	2024-12-31
Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх:		
Банкинд байршуулсан хадгаламж	13,545,704	27,709,577
Засгийн газрын бонд	-	208,021

Бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх:		
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	43,248,230	24,649,148
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	20,138,611	15,206,169
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалтын дүн	76,932,545	67,772,915

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

17. Хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг төрлөөр харуулав.

(Мянган төгрөгөөр)	Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх	Нийт дүн
Банкинд байршуулсан хадгаламж	13,547,710	13,547,710
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан	(2,006)	(2,006)
Нийт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт (дансны үнэ)	13,545,704	13,545,704

Дараах хүснэгтэд 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг төрлөөр харуулав.

(Мянган төгрөгөөр)	Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх	Нийт дүн
Банкинд байршуулсан хадгаламж	27,720,360	27,720,360
Засгийн газрын бонд	208,042	208,042
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан	(10,804)	(10,804)
Нийт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт (дансны үнэ)	27,917,598	27,917,598

Дараах хүснэгтэд 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө оруулалтыг харуулав.

(Мянган төгрөгөөр)	БДОБҮЦ-ээр хэмжигдэх	Нийт дүн
Компанийн бонд	40,623,926	40,623,926
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	2,989,806	2,989,806
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан	(365,502)	(365,502)
Нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	43,248,230	43,248,230
Компанийн хувьцаа	20,138,611	20,138,611
Нийт өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	20,138,611	20,138,611

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

17. Хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө оруулалтыг харуулав.

(Мянган төгрөгөөр)	БДОБҮЦ-ээр хэмжигдэх	Нийт дүн
Компанийн бонд	17,973,509	17,973,509
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	6,777,050	6,777,050
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан	(101,411)	(101,411)
Нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	24,649,148	24,649,148
Компанийн хувьцаа	15,206,169	15,206,169
Нийт өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	15,206,169	15,206,169

Сангийн бодлогоор хөрөнгө оруулалтын өгөөж бий болгохоос бусад стратегийн зорилгоор хөрөнгө оруулалтыг эзэмшдэг бол өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж тодорхойлдог. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх сонголтын үед, бодит үнэ цэнийн олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, цаашид болон түүнийг борлуулсан үед ашиг, алдагдалд дахин ангилж бүртгэхгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз ба тэдгээрийн буцаалт байгаа тохиолдолд бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Сангийн төлбөр хүлээн авах эрх нь ийм хөрөнгө оруулалтын өгөөж гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд ногдол ашгийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

18. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
Банкинд байршуулсан төгрөгийн харилцах данс	1,681	2,047,253
Банкинд байршуулсан долларын харилцах данс	5,750	22,788
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	7,431	2,070,041

Тайлангийн хугацааны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тавигдсан аливаа хязгаарлалт байхгүй. Сангийн гадаад валютын ханшийн эрсдэлтэй холбоотой дэлгэрэнгүйг Тодруулга 23-с харна уу.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийн зээлжих чанарыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэн нэгтгэн дүгнэж болно. Сангийн зээлийн эрсдэлийн зэрэглэл тодорхойлох системийн талаар Тодруулга 23-аас харна уу.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
Маш сайн	-	-
Хангалттай	7,431	2,070,041
Тусгай хяналттай	-	-
Дансны нийт дүн	7,431	2,070,041
Хасах: Эрсдэлийн алдагдлын хасагдуулга	-	-
Бэлэн мөнгө болон замд яваа мөнгөн хөрөнгөнөөс бусад нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,431	2,070,041

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

19. Бусад авлага

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад авлага дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,168,945	453,969
Хадгаламжийн хүүгийн авлага	321,334	467,317
Байгууллагаас авах авлага	-	157,592
Засгийн газрын бондын хүүгийн авлага	-	4,635
Нийт бусад авлагын дүн	1,490,279	1,083,513

Хүүгийн авлага нь хадгаламж болон өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хуримтлагдсан хүүг илэрхийлэх бөгөөд эдгээр авлагын хувь купон төлөлтийн хугацаа хэтрээгүй.

20. Нэгж эрх

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгж эрхийн үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
1 сарын 1-нээрх	50,000,000	50,000,000
Нэмж арилжаалсан нэгж эрх	-	-
12 сарын 31-нээрх	50,000,000	50,000,000

Сан нь нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000 мянган зарласан нэгж эрхтэй бөгөөд нийт 50,000,000 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал Ирээдүйн Өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.3 сая ширхэг нэгж эрхийг арилжсан байна. Үүнээс "Мандал Ирээдүйн Өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн 2.99 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.14 сая ширхэг нэгж эрхийг багцын арилжаагаар арилжсан мэдээллийг Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан байна.

Симбол	Арилжаалагдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш	
			2025-12-31	2024-12-28
MFG	4,771,397	5,486,253.942	980.87	1,126.00

21. Бусад нөөц

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад нөөц дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
БДОБҮЦ -ээр хэмжих өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн олз/ (гарз)	313,440	568,645
БДОБҮЦ -ээр хэмжих өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн олз/ (гарз)	(88,542)	(845,093)
Нийт бусад нөөц дансны үлдэгдэл	224,898	(276,448)

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

22. Бусад өглөг

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад өглөг дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2025-12-31	2024-12-31
ХОМК-д төлөх өр төлбөр	1,029,901	929,181
Татварын байгууллагад өгөх өр төлбөр	21,499	21,499
Компанид өгөх өр төлбөр	13,173	199,628
Кастодианд өгөх өр төлбөр	13,279	5,542
Арилжааны өр төлбөр	-	1,980,348
Нийт өр төлбөрийн дүн	1,077,852	3,136,198

ХОМК-д төлөх өр төлбөр нь тооцоолсон гүйцэтгэлийн урамшуулал болон үйлчилгээний төлбөр бөгөөд хугацаа хэтрээгүй хэвийн өглөг байна.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Сангийн гүйцэтгэх удирдлага буюу хөрөнгө оруулалтын менежментийн компани нь санхүү, үйл ажиллагаа болон хуультай холбогдох бүх эрсдэлийг хариуцан ажилладаг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (үүнд гадаад валют, хүүгийн түвшний болон бусад үнийн эрсдэл орно), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэлийг хамруулан авч үздэг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго бол эрсдэлийн хязгаарыг тогтоож, эрсдэлд орсон аливаа эрсдэлийг эдгээр хязгаарт багтаах явдал юм. Үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэлийн удирдлагын чиг үүрэг нь үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийг хамгийн бага байлгах дотоод бодлого, журмын зохистой ажиллагааг хангахад чиглэгддэг.

23.1. Зээлийн эрсдэл

Санхүүгийн хэрэглүүрийн хувьд нөгөө тал үүргээ биелүүлээгүйн улмаас санд санхүүгийн алдагдал учрах эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Энэхүү эрсдэл нь Сангийн үнэт цаасны арилжаа эсвэл санхүүгийн хөрөнгийг нэмэгдүүлэх бусад ажил гүйлгээнээс үүсдэг. Сангийн зээлийн эрсдэлд хамгийн их өртдөг дүнг санхүүгийн байдлын тайлангийн Санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэд нь тусган толилуулсан.

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэл нь Сангийн бизнесийн хамгийн том эрсдэл юм; Тиймээс удирдлага нь зээлийн эрсдэлийг болгоомжтойгоор удирддаг.

Эрсдэлийн удирдлагын зорилгоор зээлийн эрсдэлийн тооцоолол нь нарийн төвөгтэй бөгөөд эрсдэл нь зах зээлийн нөхцөл байдал, хүлээгдэж буй мөнгөн урсгал, цаг хугацаа зэргээс хамааран өөр өөр байдаг. Зээлийн багцад зориулсан эрсдэлийн үнэлгээ нь дефолт болох магадлал, алдагдлын харьцаа болон холбоотой талуудын хоорондын дефолт болох уялдааг тооцоолох шаардлагатай байдаг.

Хязгаарууд. Сан нь нэг зээлдэгч, холбоотой талууд, салбарын төвлөрөлтөд хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн хэмжээг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшинг тогтоодог. Бүтээгдэхүүн болон эдийн засгийн салбарын зээлийн эрсдэлийн түвшний хязгаарлалтыг удирдлагын зүгээс байнга баталж байдаг. Эрсдэлийг жил тутам эргэн хянадаг ба шаардлагатай тохиолдолд илүү ойрхон давтамжтайгаар хянадаг.

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэглүүрийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Сан нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагуудын (Мүүди'с, Стандарт энд Пүүрс-“S&P”, Фитч) гаргасан эрсдэлийн үнэлгээг үндэслэсэн аргачлалыг ашигладаг. Гадны болон дотоодын зээлийн үнэлгээг дотооддоо бий болгосон дефолт болох магадлалын тодорхойлогдсон үнэлгээтэй уялдуулан дараах байдлаар тооцоолдог.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.1 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем	Дотоод үнэлгээний харгалзах зэрэг
Маш сайн	AAA TO BB+
Сайн	BB TO B+
Хангалттай	B, B-
Тусгай хяналттай	CCC TO CC-
Дефолт буюу төлбөрийн чадваргүй болох	C, D-I, D-II

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг дараах байдлаар тодорхойлсон:

- Маш сайн - хүлээгдэж буй зээлийн эрсдэл багатай, чанартай зээл;
- Сайн - дунд зэргийн зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар хангалттай;
- Хангалттай - хангалттай зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар дунд зэрэг;
- Тусгай хяналттай - удирдлага илүү ойр ойрхон хяналт тавьж, арга хэмжээ авах шаардлагатай;
- Төлбөрийн чадваргүй болох - төлбөрийн чадваргүй болсон хэрэгслүүд.

Харилцагч байгууллагуудыг үнэлэхдээ хөндлөнгийн олон улсын үнэлгээний агентлагууд болох Стандарт энд Пүүрс, Мүүди'с, Фитч-зэс гаргасан үнэлгээг ашигласан. Эдгээр үнэлгээнүүд нь олон нийтэд нээлттэй байдаг. Эдгээр үнэлгээнүүд болон дефолт буюу төлбөрийн чадваргүй болох магадлалын харгалзах хүрээ нь өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (Засгийн газрын болон Компанийн бонд) зэрэг санхүүгийн хэрэглүүрүүдэд хэрэглэгдсэн.

23.2 Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт

ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй мөнгөний алдагдлын өнөөгийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жинлэсэн тооцоолол (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл төлөгдөхгүй болоход эрсдэлээр жинлэсэн дундаж алдагдал) юм. ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Сангийн ХБЭА-ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Дефолт/ Төлбөр төлөгдөхгүй болох магадлал ("PD"), Дефолт/Төлбөр төлөгдөхгүй болох үеийн үлдэгдэл ("EAD"), Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ/ Алдагдал үүсэх магадлал ("LGD") болон хорогдуулалтын хувь ("DR").

EAD гэдэг нь төлбөр төлөгдөхгүй болох үеийн үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанаас хойших төлбөрийн үлдэгдлийг таамаглахдаа зээлийн эргэн төлөлт буюу үндсэн зээлийн болон хүүгийн төлөлт, нэмж олгож болзошгүй зээлийн дүнг харгалзан авч үздэг. Хүлээж болзошгүй үүргийн биелэгдэхгүй болох үеийн зээлийн үлдэгдлийг тооцоолохдоо зээл хөрвүүлэлтийн коэффициент ("CCF") ашигладаг. CCF нь хүлээж болзошгүй үүрэг зээл хөрвүүлэлтийн магадлалын коэффициент юм. Сан хүлээж болзошгүй үүрэг 12 сарын дотор зээл рүү хөрвөх болон дуусах хугацааны турш зээл хөрвүүлэлтийн магадлалуудыг адил гэж үзсэн.

PD нь өгөгдсөн хугацааны туршид төлбөр төлөгдөхгүй болох магадлалын тооцоолол юм. LGD нь зээл/төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. LGD нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дүнд барьцаа хөрөнгө орно. LGD нь ихэвчлэн EAD-д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хорогдуулалтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшин ("EIR") юм.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.2 Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт (үргэлжлэл)

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны турш загварчилсан ба ашиглалтын хугацаа гэдэг нь өрийн хэрэглүүрийн гэрээний дагуух үлдсэн хугацаа (хэрэв төлөлт хийгдсэн бол түүнийг тохируулсан хугацаа) юм. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд энэ нь тухайн байгууллага зээлийг сунгахад гэрээгээр хүлээсэн үүрэгтэй байгааг илтгэдэг гэрээний хугацаа юм. Удирдлага нь хугацааны турш хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг загварчилдаг ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдэх хугацааны туршид үүсэж болзошгүй бүх тохиолдлоос үүсэх алдагдал юм.

12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл Санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаа нь нэг жилээс бага байгаа бол санхүүгийн хэрэглүүрт тохиолдох болзошгүй үйл явдлаас үүсэх ба ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын нэг хэсгийг илэрхийлнэ.

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагаас үнэлдэг ХБЭА нь зохицуулалтын зорилгоор ихэвчлэн ашиглагддаг мөчлөгийн тооцоолол гэхээс илүү тухайн цаг хугацааны тооцоолол байдаг. Тооцоололд ирээдүйд чиглэсэн мэдээллийг буюу зээлийн эрсдэлд нөлөөлөх макро эдийн засгийн гол хувьсагчдын жинлэсэн магадлалын дүнг ХБЭА-д тусгасан эсэхийг авч үздэг.

Дараахаас бусад тохиолдолд үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан ("POCI") санхүүгийн хөрөнгүүдийн ХЭА-ын загварчлал нь ялгаатай байдаггүй: (а) гэрээт мөнгөн урсгалд суурилсан гэхээс илүүтэйгээр хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөх үед нөхөн олгосон мөнгөн урсгалд суурилсан хөрөнгийн дансны нийт үнэ ба хөнгөлөлтийн хувь хэмжээ (б) ХБЭА нь үргэлж ашиглалтын хугацааны турш дахь ХБЭА байдаг.

POCI хөрөнгө гэдэг нь өмнөх бизнесийн нэгдлийн явцад олж авсан үнэ цэнийн бууралттай зээл гэх мэт анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

Сан дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- Зээл төлөгдөхгүй байх: Доорх нөхцөлүүд илэрсэн тохиолдолд зээлийн төлөгдөхгүй байх магадлал ихэсдэг
- гаргагч эсвэл зээлдэгч санхүүгийн хүндрэлд орсон;
- гэрээний нөхцөл зөрчигдсөн буюу хүүгийн болон үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн;
- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотой эдийн засаг, эрх зүйн шалтгаанаар зээлдэгч зээлдүүлэгчид концесс олгох;
- зээлдэгч дампуурлаа зарлах буюу санхүүгийн дахин зохион байгуулалт хийх магадлалтай байх;
- санхүүгийн хүндрэлээс болж Санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхтэй зах зээл байхгүй болох; эсвэл
- Зээлдэгч нь 90 хоногоос дээш хугацаагаар гэрээний төлбөрөө төлөөгүй.

Тодруулгын зорилгоор, Сангийн дефолтын тодорхойлолт болон хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тодорхойлолт хооронд ямар нэгэн зөрүүгүй бөгөөд дээр дурдсан дефолт тодорхойлолт нь Сангийн Санхүүгийн бүх хөрөнгөнд мөрдөгдөнө. Хэрэглүүр нь 3 сарын дараалан дефолт тодорхойлолтод заасан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд дефолтоос гарч болно. 3 сар гэдэг нь санхүүгийн хэрэглүүр дефолтоос гарсан хөрөнгө буцаж дефолт болсон хугацааны тооцоололд үндэслэн гарсан болно.

Анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн (SiCR) эсэх үнэлгээ нь зээл нэг бүрчлэн хийгддэг. Сангийн холбогдох удирдлагууд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх шалгуур нөхцөлүүдийн тохиромжтой байдлыг тогтмол хугацаатай хянаж байдаг. Зээл анх олгогдохоос хойш эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх шалгууруудын нэг болох хугацаа хэтэрсэн хоног нь 30 хоногоос дээш байх нөхцөл өөрчлөгдөөгүй болно.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.2 Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт (үргэлжлэл)

Сан нь нэг эсвэл түүнээс олон тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг SICR-тэй (Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт) гэж үздэг.

Сангийн харилцагчдын гаргасан бондын хувьд:

- 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн;
- “Тусгай хяналттай” гэсэн эрсдэлийн үнэлгээтэй болсон; Дансны болон бусад авлагын хувьд;
- 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн;

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ХБЭА-ын түвшин нь бонд гаргагчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн байгаа эсэхээс хамаарна. Энэ нь ХБЭА-ын хэмжилтийн 3-шатлалт загвар болно. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн үнэ цэнэ буураагүй мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гараагүй санхүүгийн хэрэглүүрийг 12 сарын ХБЭА (1-р шатлал)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын нөөц санг байгуулна. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш SICR гарсан бол санхүүгийн хэрэглүүрийг 2-р шатлалд шилжүүлэх боловч зээлийн үнэ цэнэ хараахан буураагүй бөгөөд эрсдэлийн санг ХБЭА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна.

Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнэ буурсан бол 3-р шатлалд шилжүүлэх бөгөөд эрсдэлийн санг ХБЭА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна. Хөрөнгө 3-р шатлалд байснаар нийт дансны үнэд суурилсан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхөө зогсоох бөгөөд хүүгийн орлогыг тооцоолохдоо ХБЭА-ыг хассан дансны үнэд хөрөнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцоолно.

Хэрэв SICR шалгуур хангагдахаа больсон гэдэг нь нотлогдсон бол хэрэглүүрийг 1-р шатлалд буцааж шилжүүлнэ. Чанарын үзүүлэлтээр үнийн дүнг 2-р шатлалд шилжүүлсэн бол Сан энэ үзүүлэлт хэвээр байгаа эсвэл өөрчлөгдсөн эсэхэд хяналт тавина.

Анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан санхүүгийн хөрөнгүүдийн ХБЭА-ыг ашиглалтын хугацааных нь туршид хэмжинэ. Иймд Сан зөвхөн нийт хугацааны турш дахь ХБЭА-д гарсан хуримтлагдсан өөрчлөлтийг хүлээн зөвшөөрнө.

Сан нь ХБЭА-ын хэмжилтийн хоёр аргатай. (i) бие даасан ганцаарчилсан үнэлгээ, (ii) багцад суурилсан үнэлгээ: зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүд (жишээ нь, PD, LGD) нь адилхан бөгөөд хөрөнгө оруулалтын багцын ижил төрлийн сегментийн хувьд ХБЭА-ын тооцооллын явцад тэдгээрийг ашиглах болон (iii) гадны эх үүсвэрт суурилсан үнэлгээ. Сан дансны ба бусад авлагууд болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгүүдийн хувьд гадны хөндлөнгийн зэрэглэлд үндэслэн үнэлгээг хийдэг.

ХБЭА-ыг ганцаарчилсан байдлаар үнэлэхдээ янз бүрийн боломжит үр дагавар тус бүрийн магадлалыг харгалзан эрсдэлийн алдагдлыг тооцоолно. Сан үнэлэгдсэн бонд тус бүрийн хувьд дор хаяж хоёр боломжит үр дагаврыг тодорхойлсон бөгөөд эдгээр хувилбарын магадлал нь магадгүй маш бага байсан ч эрсдэлийн алдагдлыг бий болгодог.

ХБЭА нь дараах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн үржвэрүүдийн нийлбэр юм: дээр тайлбарласны дагуу тодорхойлогдсон төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн, төлбөр төлөгдөхгүй болох магадлал ба төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ мөн хэрэглүүрүүдийн үр ашигт хүүний түвшинг ашиглан үнэлэх дискаунтчилсан дүнгийн нийлбэр юм. ХБЭА-ын хугацааны турш дахь эрсдэлийн параметруудийг (төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн - EAD, төлбөр төлөгдөхгүй болох магадлал - PD, төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ - LGD) тусгайлан болон багцын сегмент тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид ирээдүйн жил бүрд тодорхойлдог. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь үржүүлж, оршин тогтнох магадлалыг тохируулна (жишээ нь, өмнөх саруудад төлөгдөөгүй эсвэл дахин төлөгдсөн дүнгүүд). Энэ нь ирээдүйн ХБЭА-ыг үр дүнтэйгээр тооцоолж дараа нь тайлангийн огноо руу буцаан дискаунтчилан нэгтгэдэг. ХБЭА-ын тооцоололд ашигласан дискаунтын түвшин нь анхны үр ашигт хүүний түвшин буюу түүнтэй ойролцоо дүн байна.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.3 Зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийг тооцоолох үндсэн зарчмууд

Дефолт болсон үеийн дүнг бүтээгдэхүүний төрлөөс хамааран өөр өөр байдаг хүлээгдэж буй төлбөрийн байдалд үндэслэн тодорхойлно. Дефолт болсон үеийн дүнг 12 сар эсвэл нийт хугацааны туршид Бүтээгдэхүүнийг хорогдуулан бонд гаргагчийн төлөх ёстой гэрээний эргэн төлөлтүүдэд үндэслэнэ. Бонд гаргагчийн илүү төлөлтөөр залруулга хийгдэнэ. Хугацаанаас нь өмнө эргэн төлөлт хийх болон дахин санхүүжилт хийх эсэх талаар таамаглалуудыг мөн тооцоололд оруулдаг. Өөрчлөгдсөн бүтээгдэхүүний хувьд EAD-ийг өнөөгийн үлдэгдэл балансыг авч, үлдэгдэл нь алдаатай болох үед хүлээгдэж буй бууралтыг тооцох "зээлийн хөрвүүлэлтийн коэффициент" -ийг нэмж тооцдог.

Эдгээр таамаглал нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн хязгаарыг ашигласан байдал болон бусад тусгай төлөв байдлын онцлогоос хамааран олон янз байна.

ХБЭА-ыг тооцоолоход 2 төрлийн дефолт болох магадлалыг ашиглана: 12 сарын болон ашиглалтын хугацааны дефолт болох магадлал, 12 сарын дефолт болох магадлалын үнэлгээг хийхэд хамгийн сүүлийн үеийн ашиглах боломжтой дефолтын мэдээлэлд тохируулж ашигладаг.

Ашиглалтын хугацааны дефолт болох магадлал нь санхүүгийн хэрэглүүрийн үлдсэн ашиглалтын хугацаанд тохиолдох дефолтын магадлалыг тооцоолох ба энэ нь Санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны турш дахь 12 сарын дефолт болох магадлалын нийлбэр юм. Сан шилжих хөдөлгөөнт матрицийн статистик аргазүйг ашиглан дуусах хугацааны турш дефолт болох магадлалыг харилцагчийн ангилал болон хугацаа хэтэрсэн хоногт тулгуурлан тооцоолдог.

Тухайлбал, шилжих хөдөлгөөний матрицад суурилсан 12 сарын PD-ийг экстраполяци хийж, түүхэн дефолт өгөгдөлд суурилсан дуусах хугацааны туршийн PD муруйг сайжруулах гэх мэт.

Алдагдал хүлээх магадлал нь Сангийн дефолт болсон зээлүүдээс хүлээж болзошгүй алдагдлыг илэрхийлнэ. LGD нь Бүтээгдэхүүний төрөл, дефолт болсон хугацаанаас хамаарна. 12 сар ба дуусах хугацааны туршийн алдагдал хүлээх магадлал нь төлбөр төлөгдөхгүй болсны дараа хүлээгдэж буй эргэн төлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үздэг. Алдагдал хүлээх магадлалыг гурван боломжит аргад хувааж болно:

- Зээлийн барьцааны онцлог шинжид үндэслэсэн LGD-ын хэмжилт;
- Багцын түвшинд эргэн төлөлтийн статистикт үндэслэсэн LGD-ын тооцоолол; эсвэл
- Өөр өөр хүчин зүйлс, хувилбаруудаас шалтгаалсан тусгайлан үнэлсэн LGD-ын хэмжилт.

Сан алдагдал хүлээх магадлалыг барьцаа хөрөнгийн шинж чанараас хамааруулан тооцоолдог. Жишээ нь, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцаа хөрөнгө хямдруулж зарсан түүхэн өгөгдөл болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө, бусад хөрвөх чадвартай үнэт цаасаар баталгаажуулагдсан зээл гэх зэрэг олон шинж чанараас хамаардаг. Хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь алдагдал хүлээх магадлалын тооцоололд ордог. Хэрвээ хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь дефолт болох үеийн зээлийн үлдэгдэл (EAD)-ээс бага байвал Сан үлдэгдэл болон хувь (1- эргэн төлөлтийн хувь)-аар үржүүлж тооцсон хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ хоёрын зөрүүнээс алдагдал хүлээдэг.

23.4 Өрийн үнэт цаас (Засгийн газрын бонд, Сангийн бонд)-т оруулсан хөрөнгө оруулалтын ХБЭА-ын хэмжилт

Өрийн үнэт цаасны ХБЭА-ын хэмжилтэд дээр дурдсантай ижил алхмуудыг дагаж мөрдөж байгаа бөгөөд энэ нь эрсдэлийн хүлээгдэж буй нийтлэг алдагдлын хэмжилтийн дефолт болон SICR-ийг тодорхойлох шалгууртай ижил байна гэсэн үг юм.

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.5 Зах зээлийн эрсдэл.

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зээлийн хүү, гадаад валютын ханш зэрэг зах зээлийн хувьсах хэмжигдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгалын хэлбэлзлээс үүсэх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэхдээ удирдлагын анхаарах үндсэн зүйлс бол оролцооны хэрэгцээ шаардлага, импортын бүтэц, гадаадын харилцагч талуудын богино хугацааны өр төлбөр зэрэг юм. Сан Энэхүү эрсдэлийн үзүүлэлтийг мэдрэмтгий байдлын шинжилгээ ашиглан хянаж зохицуулдаг. Гадаад валютын хүрээнд төвлөрлийг эс тооцвол Сан зах зээлийн эрсдэлийн төвлөрөлгүй. Сан бусад үнийн эрсдэлд өртдөггүй болно.

23.6 Гадаад валютын ханшийн эрсдэл

Зах зээл дээрх гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан Сангийн эзэмшиж буй гадаад валютын актив, пассивын үнэ цэнэ өөрчлөгдөж, Сангийн ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хэмжээнд нөлөөлж байвал гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Сангийн санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан эрсдэлд өртөмтгий байдаг. Аливаа валютын хувьд ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй нээлттэй позиц нь Сангийн гадаад валютын ханшийн эрсдэлийг ихэсгэж байдаг. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тухайд удирдлага валютын өртөлтийн түвшинг хязгаарлаж, өдрийн болон шөнийн аль алинд нь нийт дүнгээр нь тогтоодог.

2025 оны 12 сарын 31-ний өдрийн Сангийн гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр харуулав.

(Минган төгрөгөөр)	Төгрөг	Ам. Доллар	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,681	5,750	7,431
Хөрөнгө оруулалт- хадгаламж	13,545,704	-	13,545,704
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	43,248,230	-	43,248,230
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	20,138,611	-	20,138,611
Бусад авлага	1,490,279	-	1,490,279
Нийт санхүүгийн хөрөнгө	78,424,505	5,750	78,430,255
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өглөг	1,077,852	-	1,077,852
Нийт санхүүгийн өр төлбөр	1,077,852	-	1,077,852
Тайлан тэнцлийн цэвэр дүн	77,346,653	5,750	77,352,403

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.6 Гадаад валютын ханшийн эрсдэл (үргэлжлэл)

2024 оны 12 сарын 31-ний өдрийн Сангийн гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр харуулав.

(Мянган төгрөгөөр)	Төгрөг	Ам. Доллар	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,047,253	22,788	2,070,041
Хөрөнгө оруулалт- хадгаламж	27,709,577	-	27,709,577
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	24,649,148	208,021	24,857,169
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	15,206,169	-	15,206,169
Бусад авлага	1,083,513	-	1,083,513
Нийт санхүүгийн хөрөнгө	70,695,660	230,809	70,926,469
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өглөг	3,136,198	-	3,136,198
Нийт санхүүгийн өр төлбөр	3,136,198	-	3,136,198
Тайлан тэнцлийн цэвэр дүн	67,559,462	230,809	67,790,271

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.7 Хүүгийн эрсдэл

Сангийн санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүгийн түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэлзлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал буурах эсвэл эсрэгээрээ нэмэгдэх ч боломжтой. Сангийн удирдлага дахин үнэлэгдсэн хүүгийн хувь хэмжээний зөрүүгийн түвшинд хязгаарлалтыг тогтоож, өдөр тутам хяналт тавьдаг.

Дараах хүснэгтэд 2025 оны Сангийн хүүгийн түвшний эрсдэлийн өртөх байдлыг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэд Сангийн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн нийлбэр дүнг хүүд өөрчлөлт орох гэрээний хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв:

(Мөнгөн төгрөгөөр)	Хугацаагүй болон 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Хүүтэй нийт дүн	Мэдрэмтгий хүүгүй дүн	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	-	7,431	7,431
Бусад авлага	-	-	-	-	-	1,490,279	1,490,279
БДӨБҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгө	424,546	11,077,216	29,983,571	1,762,897	43,248,230	20,138,611	63,386,841
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	-	444	13,545,260	-	13,545,704	-	13,545,704
Нийт санхүүгийн хөрөнгө	424,546	11,077,660	43,528,831	1,762,897	56,793,934	21,636,321	78,430,255
Санхүүгийн өр төлбөр							
2025 оны 12 сарын 31 хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү	424,546	11,077,660	43,528,831	1,762,897	56,793,934	20,558,469	77,352,403

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.7 Хүүгийн эрсдэл (үргэлжлэл)

Сангийн санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүгийн түвшний хэлбэрлэлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэрлэлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал буурах эсвэл эсрэгээрээ нэмэгдэх ч боломжтой. Сангийн удирдлага дахин үнэлэгдсэн хүүгийн хувь хэмжээний зөрүүгийн түвшинд хязгаарлалтыг тогтоож, өдөр тутам хяналт тавьдаг.

Дараах хүснэгтэд 2024 оны Сангийн хүүгийн түвшний эрсдэлийн өртөх байдлыг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэд Сангийн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн нийлбэр дүнг хүүд өөрчлөлт орох гэрээний хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв.

(Монгол төгрөгөөр)							
Хугацаагүй болон 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Хүүтэй нийт дүн	Мэдрэмтгий хүүгүй дүн	Нийт дүн	
Санхүүгийн хөрөнгө							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	2,070,041	2,070,041	
Бусад авлага	-	-	-	-	1,083,513	1,083,513	
БДӨБҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгө	1,284,585	15,197,800	8,166,763	24,649,148	15,206,169	39,855,317	
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	2,197,168	25,512,409	208,021	27,917,598	-	27,917,598	
Нийт санхүүгийн хөрөнгө	3,481,753	40,710,209	8,374,784	52,566,746	18,359,723	70,926,469	
Санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	3,136,198	3,136,198	
2024 оны 12 сарын 31 хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү	-	3,481,753	40,710,209	8,374,784	52,566,746	67,790,271	

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.8 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь Сан санхүүгийн өр төлбөрөө барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлнэ. Мөнгөн хөрөнгийн боломжит эх үүсвэрээс бэлэн мөнгөний гарах урсгалын хэрэгцээ Сангийн хувьд өдөр бүр гарч байдаг. Сангийн удирдлага төлбөрийн чадварын эрсдэлийг удирдан зохицуулдаг ба Сангийн мөнгөн урсгал, сарын төсвийг удирдлага хянаж байдаг. Сан үндсэндээ зээл, дансны болон бусад өглөгөөс бүрдэх санхүүжилтийн суурийг тогтвортой байлгахыг эрмэлздэг.

Дараах хүснэгтэд Сангийн 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх дискаунтчлагдсан мөнгөн гүйлгээнд үндэслэн санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг үзүүлэв. Ирээдүйн гэрээний хүүг оролцуулан гэрээний дагуу дискаунтчлагдаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэсэн санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь дискаунтчлагдсан мөнгөн гүйлгээнийхээс материаллаг хэмжээний зөрүүгүй юм.

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.8. Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Санхүүгийн хэрэглүүрүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь дараах байдалтай байна:

(Монгол төгрөгөөр)	Хугацаагүй болон 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,431	-	-	-	7,431
Бусад авлага	1,490,279	-	-	-	1,490,279
БДӨБҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгө	20,563,157	11,077,216	29,983,571	1,762,897	63,386,841
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	-	444	13,545,260	-	13,545,704
Нийт санхүүгийн хөрөнгө	22,060,867	11,077,660	43,528,831	1,762,897	78,430,255
Санхүүгийн өр төлбөр					
Дансны болон бусад өглөг	1,077,852	-	-	-	1,077,852
Нийт санхүүгийн өр төлбөр	1,077,852	-	-	-	1,077,852
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	20,983,015	11,077,660	43,528,831	1,762,897	77,352,403

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.8. Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Санхүүгийн хэрэглүүрүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	Хугацаагүй болон 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,070,041	-	-	-	2,070,041
Бусад авлага	1,083,513	-	-	-	1,083,513
БДӨБҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгө	15,206,169	1,284,585	15,197,800	8,166,763	39,855,317
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	-	2,197,168	25,512,409	208,021	27,917,598
Нийт санхүүгийн хөрөнгө	18,359,723	3,481,753	40,710,209	8,374,784	70,926,469
Санхүүгийн өр төлбөр					
Дансны болон бусад өглөг	3,136,198	-	-	-	3,136,198
Нийт санхүүгийн өр төлбөр	3,136,198	-	-	-	3,136,198
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	15,223,525	3,481,753	40,710,209	8,374,784	67,790,271

24. Капиталын удирдлага

Сан нь хөрөнгө оруулалт хийх замаар нэгж эрх эзэмшигчидийн хөрөнгийн үнэ цэнийг тогмол өсгөх зорилготой ба Сангийн удирдлага нь хөрөнгө оруулагчидийн итгэлийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой бодлогуудыг хөгжүүлж бий болгодог. Тайлант хугацаанд Сангийн капиталыг удирдах бодлого 9 дүгээр сард СЗХ-оос зөвшөөрөл аван шинэчилсэн.

Сангийн цэвэр актив үнэлгээг цэвэр активыг нэгж эрхийн тоонд харьцуулсан харьцаагаар хэмждэг. Цэвэр активыг тооцохдоо нийт хөрөнгөнөөс нийт өр төлбөрийг хасаж тооцно.

Сангийн үйл ажиллагааны явцад Сангийн цэвэр актив хэмжээ дараалсан арав хоногийн туршид Сан нь үйл ажиллагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40% эсхүл түүнээс илүү хэмжээгээр буурсан нөхцөлд ХОМК нь ажлын 15 өдөрт багтаан Сангийн нэгж эрх эзэмшигчидийн хурлыг зарлан хуралдуулж дор дурдсан асуудлаар шийдвэр гаргах үүрэгтэй. Үүнд:

- 5.6.1 Санг татан буулгаж хөрөнгө оруулагчдад хөрөнгийг хуваарилах эсэх
- 5.6.2 Сангийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх

СЗХ-оос тавьдаг өөрийн хөрөнгийн харьцааны шаардлага хангасан эсэхийг өдөр бүрийн бодит мэдээлэл болон сар бүр өөрсдийн хийсэн тооцоололд үндэслэн Сангийн Гүйцэтгэх захирлаар хянуулдаг.

Сангийн ирээдүйн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зах зээлд болоод хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалан ажиллахын тулд өөрийн хөрөнгийн шаардлагатай түвшинг ханган ажиллах сонирхолтой байдаг. СЗХ-оос тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагын дагуу Сан өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг (өөрийн хөрөнгийн харьцаа) заасан хамгийн бага түвшингээс дээгүүр байлгах ёстой. Сангийн өөрийн хөрөнгө нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 78,717,667 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31: 67,790,271 мянган төгрөг) байна. Сан нь 2025 болон 2024 оны эцсээр өөрийн хөрөнгийн тавигдах гадны бүх шаардлагуудыг хангаж ажилласан.

25. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

25.1. Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Сан өөрийнх нь эсрэг мэдүүлсэн нэхэмжлэл хүлээн авах тохиолдлууд байдаг. Сан шүүхийн маргааны явцад баримтлах албан ёсны хяналт тавих бодлого журамтай. Удирдлага өөрсдийн тооцоолол, дотоодын мэргэжлийн зөвлөгөөг үндэслэн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад бүртгэсэн нөөц сангийн хэмжээнээс хэтэрсэн нэхэмжлэл үүсгэсэн заргатай холбоотой материаллаг хэмжээний алдагдал үүсээгүй гэж удирдлага дүгнэж байна.

25.2. Татварын хууль тогтоомж

Монгол Улсын татварын, валютын болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх магадлалтай. Эдгээр хууль тогтоомжуудыг Сангийн ажил гүйлгээ болон үйл ажиллагаанд удирдлагын тайлбарлан хэрэгжүүлсэн байдал нь холбогдох эрх бүхий байгууллагуудынхаас зөрөх магадлалтай.

Монгол Улсын татварын байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримталж болох бөгөөд өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын байгууллага үгүйсгэх боломжтой билээ. Үүний үр дүнд мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулах магадлалтай. Татварын байгууллагууд шалгагдаж буй жилийн өмнөх таван жилийн татварыг эргэн сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд түүнээс өмнөх хугацааг хамран шалгах боломжтой.

25 Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

25.2. Татварын хууль тогтоомж (үргэлжлэл)

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутгагчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжилтийн болон бусад татварын хуулиудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Дээр дурдсанчлан захиргааны болон шүүх ажиллагааны сүүлийн үеийн өөрчлөлтийн үр дүнд татварын ийм байр суурийг өндөр хяналтад авч магадгүй юм.

Татварын байгууллагын аливаа сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй, гэсэн хэдий ч энэ нь байгууллагын санхүүгийн байдал болон / эсвэл нийт үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Сангийн удирдлага холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан хэрэгжүүлсэн байдлаа зохистой бөгөөд Сангийн татварын болон бусад хууль тогтоомжийн талаарх байр суурь тогтвортой гэж үзэж байгаа. Удирдлага татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэл бага гэж үзэж байна. Удирдлага татвараас үүсэх эрсдэлүүдээ тогтмол эргэн хянаж байдаг ба өнөө үед баттайгаар урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас ирээдүйд Сангийн байр суурь өөрчлөгдөх болно.

26. Бодит үнэ цэнийн тодруулга

Татан буугдалт эсвэл албадан борлуулалтаас бусад тохиолдолд тухайн хэрэглүүрийг сонирхож буй талуудын хоорондох сунгасан гарын зарчмын нөхцөлийн талаарх мэдлэгтэй байдал, идэвхтэй зах зээлд арилжаалагдах дүнгээр бодит үнэ цэнийг тодорхойлдог. Идэвхтэй зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэглүүр нь бодит үнэ цэнийн хамгийн тодорхой нотолгоо юм. Хэрвээ Сангийн санхүүгийн хэрэглүүрийн голлох хэсэгт идэвхтэй зах зээл байхгүй бол бодит үнэ цэнэ нь тухайн эдийн засгийн нөхцөл байдал болон хэрэглүүртэй шууд хамааралтай тусгай эрсдэлд суурилагддаг. Доорх үзүүлсэн тооцоолол нь Сангийн тодорхой хэрэглүүрийг зах зээл дээр бүхэлд нь арилжихад хэрэгжих мөнгөн дүнг илэрхийлэх шаардлагагүй болно.

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд тодорхойлох ба эдгээр нь

- (i) ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарлагдсан (тохируулагдаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно
- (ii) хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ
- (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно.

Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход ихээхэн тохируулга хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй үнэлгээний өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн тодорхойлолттой бүхлээр нь харьцуулан тооцдог.

26.1. Давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтүүд

Давтагдах бодит үнэ цэнийн хэмжилт гэдэг нь хугацаа бүрийн эцэст нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тайлагнагдах Санхүүгийн байдлын тайланд тусгахыг шаарддаг эсвэл зөвшөөрдөг хэмжилтийг хэлнэ. Бодит үнэ цэнийн ангиллын түвшинг давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтээр ангилагдсан байдлыг дараах хүснэгтэд харууллаа.

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26. Бодит үнэ цэнийн тодруулга (үргэлжлэл)

26.1. Давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтүүд (үргэлжлэл)

	2025				2024			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн	Түвшин1	Түвшин2	Түвшин3	Нийт дүн
(Миллион төгрөгөөр)								
БҮЦ-ээр хэмжигдсэн хөрөнгө								
Санхүүгийн хөрөнгө								
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	2,985,885	40,262,345	-	43,248,230	6,764,330	17,884,818	-	24,649,148
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	20,138,611	-	-	20,138,611	15,206,169	-	-	15,206,169
Давтагдах БҮЦ-ийн хэмжилтээрх хөрөнгө	23,124,496	40,262,345	-	63,386,841	21,970,499	17,884,818	-	39,855,317

Бодит үнэ цэнийн хэмжилтийн 1-р түвшинд ангилагдсан өмчийн үнэт цаас нь ихэвчлэн Сангийн хөрөнгө оруулалттай холбоотой бөгөөд эдгээр нь Монгол улсын Хөрөнгийн Бирж болон гадаад улсуудын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компаниудад оруулсан хөрөнгө оруулалт юм. Тодруулга 17-г харна уу.

Бодит үнэ цэнийг хэмжих зорилгоор 1-р түвшинд ангилагдсан ерийн үнэт цаас нь Монгол Улсын Хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй Компанийн хүүтэй бондтой, 2-р зэрэглэлийн ерийн үнэт цаас нь гадаад зах зээлийн үнийн мэдээлэл байхгүй, хаалттай зах зээлд арилжаалагддаг Компанийн бондтой холбоотой. Тодруулга 17-г харна уу.

2-р түвшинд ангилагдсан ерийн үнэт цаасны бодит үнэ цэнийг жилийн эцэс хүртэл харилцан хамааралгүй талуудын хооронд хийсэн бодит гүйлгээний үнэд үндэслэн тодорхойлсон.

“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26. Бодит үнэ цэнийн тодруулга (үргэлжлэл)

26.2. Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй боловч бодит үнэ цэнээр толилуулагдсан хөрөнгө ба өр төлбөр

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангиллын түвшингээр нь үнэлж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгийн дансны дүнг доор харуулав:

(Мянган төгрөгөөр)	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө:				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	7,431	-	7,431
Банкны хадгаламж	-	13,545,704	-	13,545,704
Бусад авлага	-	1,490,279	-	1,490,279
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн нийт санхүүгийн хөрөнгө	-	15,043,414	-	15,043,414

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангиллын түвшингээр нь үнэлж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгийн дансны дүнг доор харуулав:

(Мянган төгрөгөөр)	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө:				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	2,070,041	-	2,070,041
Банкны хадгаламж	-	27,917,598	-	27,917,598
Бусад авлага	-	1,083,513	-	1,083,513
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн нийт санхүүгийн хөрөнгө	-	31,071,152	-	31,071,152

27. Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх толилуулга

Дараах хүснэгтэнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгийг хэмжилтийн ангиллаар харуулав:

(Мянган төгрөгөөр)	Хорогдуулсан өртөг	БДОБУЦ	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,431	-	7,431
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	43,248,230	43,248,230
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	20,138,611	20,138,611
Банкны хадгаламж	13,545,704	-	13,545,704
Бусад авлага	1,490,279	-	1,490,279
Нийт санхүүгийн хөрөнгө	15,043,414	63,386,841	78,430,255

"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

27. Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх толиглуулга (үргэлжлэл)

Дараах хүснэгтэнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгийг хэмжилтийн ангиллаар харуулав:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Хорогдуулсан өртөг	БДОБҮЦ	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,070,041	-	2,070,041
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	208,021	24,649,147	24,857,169
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	15,206,169	15,206,169
Банкны хадгаламж	27,709,577	-	27,709,577
Бусад авлага	1,083,513	-	1,083,513
Нийт санхүүгийн хөрөнгө	31,071,153	39,855,316	70,926,469

28. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

2025 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн тайланг 2026 оны 2 сарын 11-нд гаргасан бөгөөд тайлант хугацааны дараа санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй дараагийн үйл явдал гараагүй болно.

29. Англи хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангууд Англи болон Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи, Монгол хувилбаруудын хооронд ялгаа эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.



 www.nexia.mn
 +976.77001500, 99070786
 info@nexiamongolia.com